

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төс өв сая. төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь
					Хагас жил		
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:							
1	Зорилго 1. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.						
1.1	6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.						
1.1.1	2.1.НЗДУАХ –ийн 6.1.1, НХТЖҮЧ-ийн 9.1.1, НХЖТ-ний 6.1.1 Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.						
1.1.2	2.1.1.Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах	338.2	УИХ-аар батлагдсан баримт бичгийн тоо	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал концепц батлагдсан	1	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж Монгол Улсын Засгийн газарт өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэртэй холбогдуулан дараах материалын бүрдлийг хангуулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. - Улсын Их Хурлын тогтоолын төсөл; - Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулга; - Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал; - Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага урьдчилсан тандан судалгааны тайлан; - Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн судалгааны тайлан; - Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан; “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барилга, хот	80%

						байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан бөгөөд одоогоор Засгийн газрын яамдаас Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал авч байна.	
1.1.3	2.1.1 Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулах	-	Засгийн газрын хурлаар батлуулсан баримт бичгийн тоо	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан	1	<ul style="list-style-type: none"> - “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барилга, хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан бөгөөд одоогоор Засгийн газрын яамдаас Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал авахаар ажиллаж байна. - “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсны дараа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөрөнгө оруулалтын нарийвчилсан тооцооны хамт Монгол Улсын Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэж байна. 	80%
1.1.4	2.1.3. Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад захиалагчийн хяналт тавих	-	Боловсруулсан ХЕТ-ний тоо	Ерөнхий төлөвлөгөө 26 ам	5 ХЕТ	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/131 дүгээр захирамжийн дагуу “Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол” боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 2022/01 дугаар зургийн даалгаврыг Нийслэлийн Засаг даргаар батлуулан Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Одоогоор худалдан авах ажиллагаа явагдаж байна.</p> <p>Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 19-р хорооны Хуурай мухар, 20-р хорооны Бэлхийн ам, Чингэлтэй дүүргийн 19-р хорооны Шадивлангийн ам, Жигжидийн амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлыг “Ланд Овнер” ХХК гүйцэтгэж байна. Тус ажлын дундын тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 16 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан. Одоогоор эцсийн тайланд Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.</p>	100%
1.1.5	2.1.4. Сонсголон, Амгалан, Шинэ төв дэд төвийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах	425.0	НИТХ-аар батлуулах баримт бичгийн тоо	-	3 баримт бичиг боловсруулсан байна.	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд шинээр 3 дэд төв, байгуулах зураг төслийн ажлууд хийгдэж байна. Үүнээс “Амгалан”, “Шинэ төв”, “Сонсголон” дэд төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн	70%

						2022 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн 13 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан. Одоогоор эцсийн тайланд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.	
1.1.6	2.1.5. Нисэх, Тахилт Дарь эх, Монель, Бичил, Ургах наран Хайлааст олон нийтийн төвүүдийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл боловсруулах	619.7	НИТХ-аар батлуулах баримт бичгийн тоо	-	7 баримт бичиг боловсруулсан байна.	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд шинээр 7 олон нийтийн төвүүдийг байгуулах зураг төслийн ажлууд хийгдэж байна. "Монель", "Тахилт", "Дарь-Эх" олон нийтийн төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын дундын тайланг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан. "Нисэх", "Хайлааст", "Бичил", "Ургах наран", олон нийтийн төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 16 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан.	70%
2	2.2. НЗДҮАХ –ийн 6.1.2, НХТЖҮЧ-ийн 9.2.1 . Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж, хотын хэт төвлөрлийг бууруулна.						
2.1	2.2.1."Яармаг" хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөөг /Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлэх	-	Шинэчлэн боловсруулсан ХЕТ-ний тоо	НИТХТ-ийн 2015 оны 198 дугаар тогтоол	1	Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/651 дүгээр захирамжийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Сонголт дизайн" ХХК-тай байгуулсан гэрээгээр гүйцэтгэж буй Улаанбаатар хотын төлөвлөлтийн "27 дугаар нэгж хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна. Мэргэжлийн зөвлөл /комисс/-ийн 2022 оны 10 дугаар хурлын санал, дүгнэлтийг үндэслэн Улаанбаатар хотын төлөвлөлтийн 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 2021/А/651/01 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл хүртэл сунгахаар гэрээний төслийг боловсруулан холбогдох баримт бичгийг 2022 оны 05 дугаар сарын 05 дугаар сарын 20-ны өдрийн 02/1842 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	40%
3	<i>Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж ыүс орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.</i>						
3.1	ЗГҮАХ-ийн 3.7.4, НЗДҮАХ-ийн 6.2.1. Дагуул хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.						

3.1.1	6.2.1. Дагуул хот байгуулах нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршлыг УИХ-аар батлуулна.	-	Саналын тоо	УБ хотын 2040 оны ХЕТ үзэл баримтлал /концепц/	1	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар Дагуул хот байгуулах нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил тодорхой болох тул хэрэгжилтийн хугацаа болоогүй.	-
3.1.2	6.2.3. Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ байршлыг тогтоож, Засгийн газраар батлуулна.	-	Саналын тоо	УБ хотын 2040 оны ХЕТ үзэл баримтлал /концепц/	1	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ, байршил тодорхой болох тул хэрэгжилтийн хугацаа болоогүй. Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газраас гаргасан хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 18-ний өдөр дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах газрын байршилтай танилцах аяллын хүрээнд Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Туушин логистикийн төсөл, Майдар хот төсөл, Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал болон ойр орчмын бүтээн байгуулалт, Эмээлт эко аж үйлдвэрийн парк, Монгол наадам цогцолборын үйл ажиллагаатай танилцсан.	-
3.1.3	6.2.4. Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулах	-	Ажлын даалгаврын тоо	УБ хотын 2040 оны ХЕТ үзэл баримтлал /концепц/	1	Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газраас гаргасан хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 18-ний өдөр дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах газрын байршилтай танилцах аяллын хүрээнд Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Туушин логистикийн төсөл, Майдар хот төсөл, Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал болон ойр орчмын бүтээн байгуулалт, Эмээлт эко аж үйлдвэрийн парк, Монгол наадам цогцолборын үйл ажиллагаатай танилцсан.	-
3.1.4	6.2.1.1. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, Бүсийн хөгжлийн хөтөлбөртэй Нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулах	-	Саналын тоо	УБ хотын 2040 оны ХЕТ үзэл баримтлал /концепц/	1	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 2022 онд Нийслэлд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажилтай холбогдуулан шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангаж, төслийн үе шатны тайланд санал өгч, холбогдох хэлэлцүүлэгт оролцож ажиллахаар тусгагдсан. Тус ажлын хүрээнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын явц, үе шатны	30%

						тайлан мэдээллийг ирүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/1030 дугаартай албан бичгийг Барилга, хот байгуулалтын сайдад хүргүүлсэн.	
3.1.5	6.2.1.2. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	11 дагуул хот, тосгодын ХЕТ батлагдсан	3 /Жаргалант, Рашаант, 361 гарам/	Нийслэлийн 2022 оны төсөвт хөрөнгийн ажил тусгагдаагүй. Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаар тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. Нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 онд албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан “Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ” боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	-
3.1.6	6.2.1.3. “Шинэ зуун мод”, “Майдар” шинэ дагуул хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэст өөрчлөлт оруулах санал боловсруулах	-	Саналын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/	1	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газраар хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Улсын Их хурлаар батлагдсаны дараагаар ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн санал боловсруулна.	-
3.1.7	6.2.1.4. Богдхан уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" байгуулах, ТЭЗҮ, боловсруулах	-	Ажлын даалгаврын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/	1	Нийслэлийн 2022 оны төсөвт хөрөнгийн ажил тусгагдаагүй. Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаар тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. - Нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 онд албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан “Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ” боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	-
3.1.8	6.2.7. Ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	-	Ажлын даалгаврын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	1	Ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08 02/325 тоот албан	-

				өний үзэл баримтлал /концепц/		бичгээр хүргүүлсэн боловч 2022 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаагүй.	
3.1.9	6.2.1.6. “Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	-	ТЭЗҮ, ХЕТ тоо	-	1	Барилгын материалын бөөний худалдааны төвийн техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08 02/325 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч 2022 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаагүй.	-
3.1.10	6.2.1.7. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхлэх	120.0	Ажлын даалгаврын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө өний үзэл баримтлал /концепц/	1	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх бодлого боловсруулах зөвлөх үйлчилгээний хөрөнгийг нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулахаар 2022 оны 02 дугаар сарын 08 02/325 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй байна.	-
3.1.11	6.2.1.8. Зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлж эхлэх	-	Санал боловсруулж, танилцуулсан тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө өний үзэл баримтлал /концепц/	1	Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа болон төлөвлөлтийн шийдлийг тусгаж ажилласан.	70%

ХОЁР . ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД

Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:

2.1	Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтаар баталсан аргачлал, загварын дагуу “Алсын хараа”, эрхэм зорилго, стратегийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн бүхий “Байгууллагын стратеги төлөвлөгөө 2021-2024”-ний төслийг нэгтгэн боловсруулж Газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. Ерөнхий архитекторын ажлын албаны чиг үүрэгт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг тухай бүр тайлагнаж ажиллаж байна.	100%
-----	---	---	---------------------------------	-----	-----	--	------

Нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн чиглэлээр тулгамдаж буй асуудлаар судалгаа хийх, төсөл хөтөлбөр боловсруулах, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнг тодорхойлох

2.2	2.3.Хүй долоо худаг дахь “Монгол наадам цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулж Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна.	-	Батлагдсан хот байгуулалтын баримт бичгийн тоо	ЗГ-ын 2016 оны 225 тогтоол	1	Хүй долоо худаг дахь “Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 99 дугаар тогтоолоор батлуулсан.	100%
2.3	2.4.Багахангай дүүргийн “Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулах	-	НИТХТ-ийн тогтоол	Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийгдсэн	1	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/528 дугаар захирамжийн дагуу “Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Аесн” ХХК шалгарч 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн №НХААГ-20/0111 дугаартай гэрээ, 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн №НХААГ-20/0111-01/01 дугаартай сунгалтын гэрээ тус тус байгуулсан. Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 241 дүгээр тушаалаар орон тооны бус экспертүүд томилогдож “Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл”-ийг хянан үзэж 2022 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн 140/2022 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт гарсан байна. “Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл”-ийг эцэслэн батлуулахаар нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурал, НИТХ-аар тус тус хэлэлцүүлэхээр холбогдох материалыг бэлтгэж НЗДТГ-т хүргүүлсэн.	90%
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:							
3.1	3.1.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн ерөнхий архитекторын 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хянаж 2022 оны 01 сарын 11-ний өдрийн 02/37 дугаар бүхий албан бичгээр “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм”-ийн 2.1 дэх заалтын дагуу НЗДТГ-т хүргүүлсэн. - Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт; - Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлт; - Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын биелэлт 	100%

	хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах					<ul style="list-style-type: none"> - Ерөнхийлөгчийн зарлигийн биелэлт - Үндэсний аюулгүй байдлын Зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн биелэлт - НЗД-ийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр - НЭЗ нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт; - НИТХ, НИТХТ-ийн тогтоол, хурлын тэмдэглэл; - Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, үүрэг даалгавар; - Нийслэлийн удирдах ажилчдын шуурхай; - Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврын биелэлт; - Нэгжийн 14 хоног, сар, улирлын тайланг цаг хугацаанд нь гаргаж Захиргаа санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. 	
3.2	3.2. Албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий архитекторын ажлын албаны жилийн төлөвлөгөөг боловсруулж газрын нэгдсэн төлөвлөгөөнд оруулж батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэлийг сайжруулан ажиллаж байна. 	100%
3.3	3.3. Албаны үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ul style="list-style-type: none"> - Монголын Мэдээ агентлагийн өдрийн хөтөлбөр болон Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрт Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хотын хэт төвлөрлийг хэрхэн сааруулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн. - Монголын Үндэсний олон нийтийн радио телевизэд явган хүний замын төлөвлөлтийн талаар мэдээлэл өгсөн. - NTV телевизэд Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд байрлах “Бату констракшн” ХХК-ийн аялал жуулчлалын сургалт, мэдээллийн төвийн барилгын талаар мэдээлэл өгсөн. - NTV телевизэд Хан-Уул дүүргийн 04, 08 дугаар хороонд аялал жуулчлалын цогцолбор зориулалтаар Архитектур төлөвлөлтийн даалгавар авсан барилгуудын талаарх мэдээллийг өгсөн. - Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай Хан-Уул дүүргийн 11 дугаар хороо Сүрьеэгийн эмнэлгийн ажилчдын 20-р байр, Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороо СТ-01, СТ-02, СТ-03, СТ-04, СТ-05 дугаар байрыг буулган шинээр барих ажлын төсөл хэрэгжүүлэгчдийн батламжийг гардуулж гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдээллүүдийг Хот байгуулалт, хөгжлийн газрын вэб сайт, 	100%

						<p>facebook page хуудас болон Ulaanbaatar.mn, нийслэлийн мэдээ facebook page хуудсанд байршуулан иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэл өгч ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Fosuc.mn сайтад 2022 онд олгосон Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл болон барилгын угсралт ажил удаан хугацаагаар зогссон аж ахуй нэгжид хүргүүлсэн хамгаалалтын горимд шилжүүлэх тухай зөвлөмжийн талаар мэдээлэл өгсөн. - Focus.mn сайтад 2022 онд олгосон барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн талаарх мэдээлэл өгсөн. - Focus.mn, TV-6, NTV телевизэд Хан-Уул дүүргийн 15-р хорооны нутаг дэвсгэрт “Эм энд Жи” ХХК-ний хэрэгжүүлж байгаа усан парк, спорт цогцолборын талаарх мэдээлэл өгсөн. 	
3.4	3.7.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 захирамжийн хэрэгжилтийг ханган тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ul style="list-style-type: none"> - 2022 оныг Нийслэлийн хэмжээнд “Хотын иргэний жил” болгон иргэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан Зохицуулалтгүй гудамж, зам талбайн худалдааг тогтсон байршил, цаг хугацаанд үйл ажиллагаа явуулах орчин нөхцөлийг бий болгох замаар иргэдийн ажлын байр, орлого, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх амралт зугаалгын бүс байгуулж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар судалгаа боловсруулах ажилд хамтран ажилласан. 	100%
3.5	Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах	-	Сургалтад хамрагдсан цаг /1 албан хаагч/	1 албан хаагчийн сургалтад хамрагдсан цаг дунджаар 60 цаг	1 албан хаагчийн сургалтад хамрагдах цаг дунджаар 40 цагаас багагүй байх	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/59 дугаар захирамжаар баталсан хуваарийн дагуу Нийслэлийн хэмжээнд томоохон хэмжээний гамшиг, осол, аюулт үзэгдэл болсон үед орон гэргүй болсон иргэдийг түр орон байраар хангах чиг үүрэг бүхий Түр орон байраар хангах албаны нийт бүрэлдэхүүн, орон тооны бус штабын бэлтгэл бэлэн байдалд хийсэн Нийслэлийн Засаг даргын нэрэмжит үзлэг, шалгалтад оролцсон. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног болгоны Пүрэв гаригт явуулдаг 7:4:10 арга зүйн цахим сургалтад хамрагдсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - “Улсын их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулах харилцааны талаар” - Орчин үеийн хөгжлийн мега трендүүд” - “Албан ёсны статистик ба их өгөгдөл” - “Аз жаргалтай ажиллахын нууц “монгол орны хэтийн төлөв” - “Манлайллын хэв маяг, хандлага тодорхойлох нь” 	100%

							<ul style="list-style-type: none"> - "Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь" - "Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил" - "Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхлаас ангид байх" 	
3.6	Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	Албан бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэлтийг чанаржуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	100	2022 оны хагас жилийн байдлаар нийт хариутай хариугүй нийт 134 албан бичиг ирж, 72 албан бичиг төлөвлөж явуулсан. Албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж 10 хоног байна.	100%
		Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг EDOC системээс хэвлэн, архивлах - Ирсэн бичгийн бүртгэл хяналтын картыг хэвлэх, цахимаар ирсэн бичгийг бүртгэл хяналтын картын хамт EDOC системээс хэвлэн, архивлах (үндсэн үйл ажиллагааны чиглэлээр)		Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр	Үгүй	Тийм	2022 оны хагас жилийн байдлаар Ерөнхий архитекторын ажлын албанд үндсэн чиг үүргийн хүрээнд ирсэн бичгийг цахим болон цаасан хэлбэрээр архив үүсгэж, нэг хувийг НЗДТГ-т хүргүүлэн ажиллаж байна.	100%
3.7	Өргөдөл гомдлыг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	Шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, эцэслэн шийдвэрлэх		Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	8 хоног	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 18 өргөдөл ирсэн бөгөөд асуудлыг судалж дунджаар 2 хоногт шийдвэрлэсэн.	100%
3.8	3.16. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх			Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Албанаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу Захиргаа санхүүгийн хэлтэст архивын 12 боть баримт бичгийг хүлээлгэн өгсөн.	100%
ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД								

4	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтэц, барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ.						
4.1	Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд I-UP мэдээллийн цонхыг тогтмол ажиллуулах	-	I-UP мэдээллийн цонхонд мэдээ мэдээлэл байршуулсан тоо	1	2	- Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг УИХ-аар батлагдахаар I-UP мэдээллийн цонхонд байршуулахаар төлөвлөж байна.	-

Төлөвлөгөөг үнэлсэн:

Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга

(албан тушаал)

Төсвийн Шууд захирагч

..... / **Ц.Тулга** /

(гарын үсэг)

..... (огноо)

Тайлагнасан:

Ерөнхий архитекторын ажлын албаны дарга.

(албан тушаал)

Нэгжийн дарга

..... / **Д.Ганчимэг** /

(гарын үсэг)

..... (огноо)